



Огноо: 2019.04.09

ЗАВХАН АЙМГИЙН МАЛЫН ГАРАЛ ҮҮСЛИЙН МӨШГӨХ ТОГТОЛЦООНЫ СИСТЕМИЙН  
ИЖ БҮРДЭЛ БОЛОХ КОМПЬЮТЕР, ПРИНТЕРИЙГ 21 СУМАНД НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН  
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт/  
гэрээний нэр, дугаар:

Завхан аймгийн малын гарал үүслийн мөшгөх тогтолцооны  
системийн иж бурдэл болох компьютер, принтерийг 21 суманд  
нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил  
Дугаар:09-XA-14/2019

Захиалагч:

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Улиастай сум 2019 он

**БАТЛАВ:**

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗРЫН ДАРГА**

**Д.БАТМЭНД**

Огноо: 2019.04.09

**ЗАВХАН АЙМГИЙН МАЛЫН ГАРАЛ ҮҮСЛИЙН МӨШГӨХ ТОГТОЛЦООНЫ СИСТЕМИЙН  
ИЖ БҮРДЭЛ БОЛОХ КОМПЬЮТЕР, ПРИНТЕРИЙГ 21 СУМАНД НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН  
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/  
гэрээний нэр, дугаар:

Завхан аймгийн малын гарал үүслийн мөшгөх тогтолцооны  
системийн иж бүрдэл болох компьютер, принтерийг 21 суманд  
нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил  
Дугаар:09-ХА-14/2019

**Захиалагч:**

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**Улиастай сум 2019 он**



## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

**Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Завхан аймгийн малын гарал үүслийн мөшгөх тогтолцооны системийн иж бүрдэл болох компьютер, принтерийг 21 суманд нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг** сонгон шалгаруулах тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Үнийн саналыг **2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 10 цаг 30 минут-аас өмнө Завхан аймаг. Улиастай сум. Нутгийн удирдлагын ордон. Орон нутгийн өмчийн газар 4-р давхарт №417 тоот өрөө утас 70462369, 99909110** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 11 цаг 00 минут-т** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Завхан аймаг. Улиастай хот. Нутгийн удирдлагын ордон. Орон нутгийн өмчийн газар 4-р давхарт №417 тоот өрөө, Утас: 70462369, 99909110.**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |  |  |
|--|--|
| <p>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</p> <p>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</p> <p>3. Тендерийн иж бүрдэл</p> <p>4. Тогтмол үнэ</p> <p>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</p> <p>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</p> <p>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</p> | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p> <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>(а) Үнийн санал;</li><li>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;</li><li>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;</li><li>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;</li><li>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]</li></ul> <p>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</p> <p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p> <p>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.</p> <p>6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> |
|--|--|

- 8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-НЫ ХОЛБОГДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p><b>Завхан аймгийн малын гарал үүслийн мөшгөх тогтолцооны системийн иж бүрдэл болох компьютер, пртинтерийг 21 суманд нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил Дугаар:09-ХА-14/2019</b></p> <p>1. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээний үүргийн биелэлтийг захиалагчийн техник, хяналт хийсэн хуулийн этгээдээс өгсөн тодорхойлолтыг үндэслэн гэрээг хэрэгжүүлэх чадварын үнэлгээнд харгалзан үзнэ. Гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн комиссын актын хуулбарыг хавсаргана.</p> <p>Нотариатаар баталгаажуулан ирүүлнэ Дуусаагүй гэрээний хувьд тайлбар хийсэн байна.]</p> <p>2. Хүчин төгөлдөр Улсын бүртгэлийн гэрчилгээг тендер зарласнаас хойши хугацаанд нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>3. Харьяа татварын алба болон нийгмийн даатгалын газраас өр, төлбөрийн талаар тодорхойлолт авч тендерт хавсаргаж ирүүлнэ. Монгол улсын хуулийн дагуу татвар , хураамж, төлбөрөө төлсөн байна./Шаардлагатай гэж үзвэл захиалагч тендерт оролцогчийн татвар, НД-ын талаарх мэдээллийг холбогдох татвар, НД-ын байгууллагаас тендерийн нээлт хийсэн өдрөөр тодруулга авна./</p> <p>4. Захиалагч татвар, НД-ын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>5. Харилцагч банкнаас тодорхойлолт ирүүлнэ.Захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>6. Борлуулалтын хэмжээ: [Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 он] Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртөгийн 50%-иас багагүй байна</p> <p>7. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын санхүүгийн тайланг татвар төлөгчдийн мэдээллийн сангаас тендерт оролцогчдын татвар төлөлт, борлуулалтын орлого, ашиг зэрэг мэдээллийг шалгана.</p>

	<p>8. НД-ын шимтгэл төлөлтийн тайланг тендер нээх хугацаанаас өмнөх хамгийн багадаа 3 сарын тайланг хавсаргаж ирүүлнэ.</p> <p>9. Харьяа шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>10. 2017, 2018 онуудад ашигтай ажилласан байна.</p> <p>11. Техникийн тодорхойлолтонд дүйцэхүйц байна.</p> <p>12. Бараа хүлээж авах эцсийн цэг: Завхан аймгийн Засаг даргын тамгын газар</p>
ТОӨЗ 2.1	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендер хүлээн авах этгээд: <b>Т.Сайннямбуу</b> Байгууллагын хаяг: <b>Завхан аймаг.Улиастай хот.Нутгийн удирдлагын ордон.Орон нутгийн өмчийн газар</b> Давхар болон өрөөний дугаар: <b>4-р давхарт №417 тоот</b> Аймаг, хот: <b>Завхан аймаг.Улиастай хот</b> Шуудангийн дугаар: <b>байхгүй</b> Улс: <b>Монгол Улс</b> Тендер хүлээн авах эцсийн хугацаа: Огноо: <b>2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр</b> Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: <b>Завхан аймгийн Нутгийн удирдлагын ордон.Орон нутгийн өмчийн газар</b> Давхар болон өрөөний дугаар: <b>4-р давхар №417</b> Аймаг, хот: <b>Завхан аймаг.Улиастай хот</b> Шуудангийн дугаар: <b>байхгүй</b> Улс: <b>Монгол Улс</b> Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <b>2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр</b> Цаг: <b>11 цаг 00 минут</b></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ХАВСРАЛТ-1

### БАРААНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

#### Компьютер, принтер нийлүүлэх

Бараа 1.1. Компьютер, принтер /иж бүрэн/

Төсөвт өртөг: 50,000000 /тавин сая / төгрөг

Тоо хэмжээ: тус бүрээс 21 /хорин нэг/ ширхэг

#### ЗӨӨВРИЙН КОМПЬЮТЕРИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Асуулт	Техникийн тодорхойлолт, стандартын шаардлага
1	Процессор	CPU: 7 <sup>th</sup> Generation intel Core™ i5-7500u Processor (3M Cache, up to 3.50GHz)
2	Шуурхай санах ой /RAM	8GB Single Channel DDR4 2400MHz (8Gx1)
3	Дэлгэц / Display	15.6 inch LED Backlit Display with Truelife and HD resolution (1366 x 768)
4	График	AMD Radeon™ R7 M445 Graphics 4GB GDDR5
5	Багтаамж /HDD	1TB 5400rpm SATA Hard Drive
6	CD/DVD уншигч	Tray load DVD Drive (Reads and Writes to DVD/CD)
7	Интерфейс	1HDMI v 1.4A 2USB 3.0 1USB 2.0 1Noble lock slot
8	Media Card Reader	1SD card (SD, SDHC, SDXC)
9	Audio and Speaker	2 tuned speakers with Waves MaxxAudio Pro, 1combo headphone /microphone jack
10	Камер /Мікрофон	Integrated widescreen HD (720p) Webcam with Dual Digital Microphone Array
11	Wireless /утасгүй сүлжээ	802.11ac +Bluetooth 4.2, Dual Band 2.4&5 GHz, 1x1
12	Баттерей	42Wh, 3-Cell Battery (integrated)
13	Dell mouse	yes
14	Цүнх	yes
15	Үйлвэрлэгчийн нэр, код, хаяг	Үйлдвэрлэгчийн нэр, хаягийг бичсэн байна
16	Үйлдвэрлэсэн он	2018 он
17	Санал болгох бодит бодит загвар	Санал болгож буй загварыг харуулсан баримт ирүүлнэ

18	Загвар	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэгчээс хэвлэн гаргасан катологи дээрх моделийн марк, хэмжээ, өнгөтэй нийтуулэгчийн санал болгож буй компьютерийн загвар нь тохирч байх.</li> <li>Энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл бий болно.</li> </ul>
----	--------	--

## Принтерийн техникийн тодорхойлолт

д/д	Асуулт	Барааны техникийн тодорхойлолт, стандартын шаардлага
1	Хэвлэх нягтаршил	1200 x 600 dpi
2	Хэвлэх хурд	26 ppm
3	Үйлдэл	<ul style="list-style-type: none"> <li>✓ хэвлэх</li> <li>✓ скайнер</li> <li>✓ канон</li> </ul>
4	Цаасны хэмжээ	A4
5	Хүчдэл	220-240V AC
6	Үйлдлийн систем	Windows 7/8/10
7	Баталгаат хугацаа	6 сар

БОЛОВСРУУЛСАН: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Н.БАТБАЯР

ХЯНАСАН: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА *ж.батцэнгэл* Ж.БАТЦЭНГЭЛ

1. Бараа хүргэх газар: [Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар]

2. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1							

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>   | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>   | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн <b>[moο]<sup>1</sup></b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup></b>  | 9.1. Алданги оногдуулах хувь: <b>[moο]</b><br>Алдангийн нийт дүн: <b>[moο]</b>   |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнэ.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дунгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>3</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүний хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]